



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 5168

Улаанбаатар хот

Ж.Даваасүрэнг ажилд томилох тухай

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 16 зүйлийн 16.1, 16.5 дахь заалт, Нийслэл дэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 175 дугаар тогтоол, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жамбал овогтой Даваасүрэнг “Дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн” албан тушаалд 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн нэг жилийн туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2. Ж.Даваасүрэнгийн сарын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээний дагуу /ТЗ-5-1/ 443.433 /дөрвөн зуун дөчин гурван мянга дөрвөн зуун гучин гурав/ төгрөгөөр цалинжуулж, холбогдох журмын дагуу унаа, хоолны хөнгөлөлтийг олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Ж.Даваасүрэнгийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ц.Цог/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН